

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2020 ОНЫ 07 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар: Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа хуралдаж, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Ховд аймгийн тусгах саналын төслийг хэлэлцэж, Үндэсний хөгжлийн газарт хүргүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст үүрэг болгов.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 11 өргөдөл бичгээр хүлээн авч, 11 өргөдлийг шийдвэрлэлээ. Аймгийн Засаг даргын Тамгын газарт 6 өргөдөл бичгээр хүлээн авч, 5 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байгаа ба өргөдөл гомдлын шийдвэрлэлт 93.75 хувьтай байна.

Угтах үйлчилгээ-Иргэдийн санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авах 7043-1111 төв"-д 1 сувгаар 2 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 2 санал хүсэлт ирүүлснээс гомдол 2 бүртгэж холбогдох хэлтэс, тасгийн дарга нарт шилжүүлж шийдвэрлэлтийн шатандаа хүлээгдэж байна. Үүнд цахилгаан эрчим хүчний асуудлаар 1, орчны эрүүл ахуйн асуудлаар 1 тус тус хандсан.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй, Засгийн газрын 1111 төвд ирсэн 3 гомдол хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, хугацаанд нь шийдвэрлэж мэдээлэв.

Нэг цонхны үйлчилгээ аймгийн ЗДТГ-т байрлаж Улсын бүртгэлийн хэлтсийн Жаргалант сумын 2 бүртгэлийн байцаагч 12 төрлийн үйлчилгээгээр 338 иргэнд, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 3 мэргэжилтэн 15 төрлийн үйлчилгээгээр 3576 иргэнд нийт 5 мэргэжилтэн 27 төрлийн үйлчилгээгээр тайлант сард 3914 иргэнд үйлчилгээ үзүүлж ажиллав.

Аймгийн Онцгой комиссын ажлын талаар: Аймгийн Онцгой комисс 2020 оны 07 дугаар сард 5 удаа хуралдаж Ховд аймагт үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай 7 асуудлыг хэлэлцэн, холбогдох асуудлаар 6 тогтоол, 3 албан бичиг гаргаж холбогдох албан байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын “Хэсэгчилсэн хөл хорио тогтоох тухай” 2020 оны А/352 дугаар захирамжаар гоц халдвар тарваган тахал өвчний сэжигтэй тохиолдлын нууц үеийн хугацаанд 1 дүгээр хавьтлуудаас сэжигтэй тохиолдол илрээгүйтэй холбогдуулан Жаргалант, Цэцэг сумдын иргэн болон нийтийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг 2020 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 13:00 цагаас эхлэн цуцалж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасаг, Цэцэг сумын Эрүүл мэндийн төвд хорио цээрийн дэглэмийг тодорхойгүй хугацаагаар тогтоосон.

Тарваганы ан агнуур хийлгэхгүй байх, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, сум орон нутаг, төв суурин газрууд руу

тарваганы мах, түүхий эд оруулахгүй байх тал дээр онцгой анхаарч, хяналт шалгалтыг зохион байгуулж холбогдох мэргэжлийн байгууллагуудын алба хаагчид хяналт тавьж ажиллалаа.

Гоц халдварт тарваган тахал өвчнөөр өвчилсөн иргэдийн хяналтын шинжилгээний хариу 3 удаа сөрөг гарсантай холбогдуулан 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 16:00 цагаас эхлэн хэсэгчилсэн хөл хориог цуцалж, хяналтын пост, хамгаалалт зохицуулалтанд үүрэг гүйцэтгэж ажилласан алба хаагчдын хоол хүнсний зардал 1.644.000 төгрөг /нэг сая зургаан зуун дөчин дөрөв/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж шийдвэрлэв.

Гоц халдварт тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах, тандалт судалгаа хийх аймгийн Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр албан даалгавар гаргаж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын даргын баталсан “Амны хаалтаа зүүцгээе” аян өрнүүлэх удирдамжийн хүрээнд орон нутгийн хэмжээнд “COVID-19” халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хүн ам олноор цуглардаг худалдаа, үйлчилгээний газруудаар аймгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл урлагийн газар, Жаргалант сум хамтран өдөр бүр ажиллах хувиар гаргаж 7 хоног бүр ард иргэдийг маск зүүж хэвшүүлэх, масктай үйлчлүүлдэг байх талаар иргэд олон нийтэд чиглэсэн ухуулга сурталчилгаа, сэрэмжлүүлэг, мэдээллийг орон нутгийн телевиз болон цахим сайтуудаар дамжуулан ажиллаж байна.

Ховд аймгийн Буянт суманд байрлах “Вестерн холд ХХК”-ны “Ховд эко цемент” төслийн үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийн угсралтын ажил хийхээр Замын үүд боомтоор орж ирэх БНХАУ-ын 14 /мэргэжилтэн/ иргэний тусгаарлах байрыг Ховд эко цементийн үйлдвэрийн барилга угсралтын орчинд Эрүүл мэндийн сайдын 2020 оны 269 дүгээр тушаалын дагуу байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ эрхэлдэг дэлгүүр, баар, ресторан, караоке, үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг 2020 оны 07 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 08:00-23:00 цаг хүртэл ажиллуулах шийдвэрийг гаргаж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 7 дугаар сард улсын төсвийн санхүүжилт 44786.5 сая төгрөг ирэхээс 42592.2 сая төгрөг ирж, цалин хөлс, тогтмол зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгож санхүүжүүлээ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийн 5152,4 сая төгрөгийн санхүүжилтээс 2958.1 сая төгрөгийн санхүүжилт ирж аймаг, сумдад хуваарийн дагуу олголоо.

Сумдын санхүүгийн дэмжлэгт 7577.7 сая төгрөг, аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагуудад 4860.1 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтээс сургуульд 19028.1 сая төгрөг, цэцэрлэгт 8326.6 сая

төгрөг, хүн эмнэлэгт 3595.0 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 298.7 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 316.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.

Төсөвт болон аж ахуйн нэгжүүдийн 2019 оны санхүүгийн тайлан тэнцэл хүлээн авсан дүн, төсвийн гүйцэтгэлийн талаар аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдэд мэдээлэл хийж, хэлэлцүүлэн цаашид авах арга хэмжээний талаар шийдвэр гаргуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Орон нутгийн төсвийн 2020 оны 2 дугаар улирлын орлогын бүрдүүлэлт, зарлагын зарцуулалтын урьдчилсан гүйцэтгэлийг гарган судалгаа, шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлын чиглэл боловсруулж танилцуулга бэлтгэн боршрут ном болгон 12 хувь олшруулж аймгийн удирдлагуудад хүргүүлэв.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд И-баланс системд цахим хэлбэрээр хүлээн авах, хянан баталгаажуулах, бүртгэлийн алдааг залруулах зэрэг арга зүйгээр ханган ажиллаж байна. Хуулийн хугацаанд нийт 522 аж ахуйн нэгж байгууллагын тайлан хүлээн авахаас 488 тайлан хүлээн авсан нь 93.6 хувьтай байна. 2020 оны 07 дугаар сарын 28-ны байдлаар аймгийн хэмжээнд нийт 17 сум, 162 байгууллагын 7044 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 5865 мэдээллийг байршуулсан, нийт байршуулсан мэдээллийн 5146 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж, шилэн дансны мэдээлэл байршуулсан дундаж үзүүлэлт 82,4 хувьтай байна.

Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 6937 ширхэг зардлын ваучер бичиж, 21045,2 сая төгрөгийн зарлагын гүйлгээг зардлын ваучераар гүйцэтгэж ажилласан.

Орон нутгийн төсвийн орлогод 5499,9 сая төгрөг орж, төлөвлөгөө 481,3 сая төгрөгөөр буюу 9,2 хувиар, үүнээс татварын орлогоор 4538,1 сая төгрөг орж төлөвлөгөө 354,8 сая төгрөгөөр буюу 8,5 хувиар, татварын бус орлогоор 816,8 сая төгрөг оруулж төлөвлөгөө 66,9 сая төгрөгөөр буюу 8,9 хувиар, хөрөнгийн орлого 59,6 сая төгрөгөөр тус тус давж биелсэн урьдчилсан дүнтэй байна.

Орон нутгийн төсвийн нийт зарлага 38799,7 сая төгрөгт хүрч, төсөвлөснөөс 8928,7 сая төгрөгөөр, үүнээс орон нутгийн төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зарлага 9105.6 сая төгрөг хүрч, 2315.4 сая төгрөгөөр, орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын зарлага 30694.1 сая төгрөгт хүрч, 6613.3 сая төгрөгөөр, ОНХС-ийн хөрөнгө оруулалтын зарлага 1772,6 сая төгрөгт хүрч, төсөвлөснөөс 750,1 сая төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтын зарлага 326,8 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 78,3 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй гарсан.

Орон нутгийн төсвийн өр 281,5 сая төгрөг, авлага 509,3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс өр 1699,3 сая төгрөгөөр, авлага 320,9 сая төгрөгөөр тус тус буурсан, нийт өрийн 34,3 хувь буюу 96,8 сая төгрөгийг үндсэн цалин, 40 хувь буюу 112,7 сая төгрөгийг тогтмол зардал, 8,3 хувь буюу 23,4 сая төгрөгийг бусад зардал, 17,3 хувь буюу 48,6 сая төгрөгийг норматив зардал тус тус эзэлж байна.

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын зарлага 326,8 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зарлага 1772,6 сая төгрөг, байгаль хамгаалах сангийн зарлага 105,3 сая төгрөг, замын сангийн зарлага 144,6 сая төгрөг, хөшөөт хөгжил сангийн зарлага 70,0 сая төгрөг, нийт 2419,9 сая төгрөг зарцуулсан нь төсөвлөснөөс 2478,8 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн, Энэ улирлын байдлаар улсын төсөвт төвлөрүүлэх орлогод 1644,0 сая төгрөг оруулахаас 1832,3 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 110.0 хувь биелүүлэв.

Орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагуудын өөрийн орлогод 55,5 сая төгрөг орж, төлөвлөгөө 75,9 хувийн биелэлттэй байна.

Эрүүл мэндийн салбарын төсвийн зарлага 3266.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 176.4 сая төгрөгөөр дутуу гарч, өр 157.7 сая, авлага 5.5 сая төгрөг гарсан нь өмнөх оны мөн үеэс өр 105.6 сая төгрөгөөр өсөж, авлага 2.7 сая төгрөгөөр буурсан байна. Өр их хэмжээгээр өссөн нь эм, эмийн хэрэгсэл их хэмжээгээр нийлүүлсэн болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилт дутуу олгогдсонтой холбоотой байна.

Боловсролын байгууллагын салбарын төсвийн зарлага 23337,3 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 2610,7 сая төгрөгөөр дутуу гарч, өр 116,4 сая, авлага 20,5 сая төгрөг гарсан нь өмнөх оны мөн үеэс өр 684,2 сая төгрөгөөр буурч, авлага 16,1 сая төгрөгөөр өссөн байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тамгын газар, Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, хотын хөгжлийн сангийн 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийлээ. Мөн Сангийн сайдын баталсан Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн зураг төсөл болон батлагдсан төсвийн хэмжээ, түүний гүйцэтгэлийн байдалд хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах, санал боловсруулах удирдамжийн дагуу Ховд аймагт хийгдэж байгаа ажлын талаарх судалгаа СТСХ, ХОХБХ-ээс гаргуулан авч, Сангийн яаманд илгээн, улсын хэмжээнд нэгтгүүлэв.

Хугацаа хэтэрсэн, актын төлбөрөө төлөөгүй 18 хүнтэй холбоотой 18805,3 мянган төгрөгийн актыг барагдуулахаар шүүхэд шилжүүлснээс 4 акттай холбоотой 1448,3 мянган төгрөгийг барагдуулж, нэхэмжлэлээс татгалзаад байна. Бусад нэхэмжлэлийн дагуу шүүх хурал товлогдсон бөгөөд тус албанаас итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон ажиллуулж байна.

Аймгийн Татварын хэлтэс нь 2020 оны 2 дугаар улирлын ААНОАТ-ын тайланг 75.3 хувьтай, тайланг 74.1 хувьтай, НӨАТ-ийн тайланг 100 хувьтай, суутгагчийн хувь хүнээс суутгасан тайланг 75.3 хувьтай тус тус хүлээн авч, тайлант хугацаанд бүртгэгдсэн ААНБ-уудыг аймгийн улсын бүртгэл, статистикийн хэлтэстэй тулгалт хийж Тахаст болон Tips программд бүртгэлээ. Үүнд: ХХК 75, Нөхөрлөл 4, төрийн бус байгууллага 9, салбар 1, сан 1, хоршоо 4 нийт 96 аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан. 2020 оны 07 сарын 28-ны байдлаар улс, аймаг, сум орон нутгийн төсөвт

7508.0 сая төгрөг оруулахаас 7996.9 сая төгрөг орсон нь 106.5 хувьтай байна. Үүнээс улсын төсөвт 2003.4 сая төгрөг оруулахаас 2162.1 сая төгрөг оруулсан нь 107.9 хувийн, аймгийн төсөвт 4409.7 сая төгрөг оруулахаас 4647.4 сая төгрөг оруулсан нь 105.4 хувийн, сум орон нутгийн төсөвт 1094.9 сая төгрөг оруулахаас 1169.8 сая төгрөг оруулсан нь 106.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хяналт шалгалтанд 13 татвар төлөгчийг хамруулж, татвар төлөгчийн гаалийн болон хөндлөнгийн мэдээллийг ашиглан шалгаснаар шалгалтын явцад 3703,8 сая төгрөгийн зөрчилд 123,2 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулж, хуулийн дагуу 26,4 сая төгрөгийн торгууль, нийт 3,7 сая төгрөгийн алданги нийт 153,9 сая төгрөгийн нөхөн татвар торгууль, алданги ногдууллаа.

Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд: Захиргааны болон иргэний хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 4 шүүх хуралдаанд хариуцагч, нэхэмжлэгчийг төлөөлж оролцсон. Шийдвэрлэгдээгүй байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхээс шаардсан нотлох баримтуудыг нотлох баримтын шаардлага хангуулан хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Аймгийн Архивын тасаг тайлант сард 85 хүнд архивын лавлагаа олгосноос, тушаалын хуулбар 22, цалингийн тодорхойлолт 27, малын тооллогын бүртгэлийн лавлагаа 31 хүнд олгож, холбогдох баримт олдоогүй 5 иргэнд шүүхээр шийдвэрлүүлэхээр албан бичиг хүргүүллээ. Тасгийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа хөмрөгийн хадгаламжийн нэгжид тооллого явуулснаас 1922-2011 оны 30 хөмрөгийн 57 дансны 11025 хадгаламжийн нэгжид тооллого хийж, илтгэх хуудас, тооллогын хуудас хөтөлсөн. Цахимжуулалтын ажлын хүрээнд 1978-1986 оны 2 хөмрөгийн 3 дансны 2875 ширхэг хуудас буюу 19 хадгаламжийн нэгж баримтыг цахимжуулан лавлагаа магадлагаа олгож байна.

Шүүхийн шинжилгээний алба: Шүүхийн шинжилгээний албанд хандаж 20 албан бичиг, шинжилгээ хийлгүүлэх тогтоол, захирамж 203 ирүүлснийг хүлээн авч, бүртгэн хугацаанд нь шийдвэрлэж, байгууллагаас 7 бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Эд эсийн шинжилгээг дамжуулж, блокыг дагалдах хуудсын хамт Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хүргүүлж, хариуг албаны цахим khovd_nifs@yahoo.com хаягаар авч ажиллаж байна.

Алба хаагч нар алсын дуудлаганд 6 удаа явж, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 8 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 149, эд эсийн шинжилгээг 8, хавтаст хэрэг 2, тусгай шинжилгээ 27, 17 криминалистикийн шинжилгээг тус тус хийж, дүгнэлт гаргаж ажиллав.

Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 43 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 65 ширхэг мөр, гутлын мөр 10, тээврийн хэрэгслийн мөр 17, биологийн гаралтай ул мөр 3, 15 бусад ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 11, гарын мөр 30 авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийсэн.

Цагдаагийн газар: Тус газраас тайлант сард иргэд, олон нийтийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Улс болон аймгийн хэмжээнд явагдаж байгаа “Яараад яахав дээ”, “Ирлээ явлаа цэвэр”, “Мотоцикл” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, аяныг хариуцсан нутаг дэвсгэрт төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган, биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна. Тухайлбал: Орон нутгийн замд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хяналт, шалгалтыг тогтмол зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг засуулан, 1150 жолооч, зорчигчдод хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, замын хөдөлгөөнд оролцох, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх талаар яриа таниулга хийж, улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Яараад яахав дээ” аянд нэгдэхийг уриалан, гарын авлага, постер, санамж, сэрэмжлүүлгийг тараан мэдээллийг тухай бүр иргэдэд хүргэж ажиллалаа.

Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Авто тээврийн төв, Эрүүл мэндийн газартай хамтран Манхан сумын замын байнгын хяналтын постод “Ааваа ээжээ та битгий яараарай” өдөрлөгийг зохион байгуулж, хөдөлгөөнд оролцож байгаа 650 орчим жолооч, зорчигчдод мэдээлэл өгч, аяны үйл ажиллагааг сурталчилсан. Мөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий 5 хулдаасан самбарыг аймгийн төв 4 замын уулзвар болон орон нутгийн замд байршуулсан.

Аймгийн Онцгой байдлын газартай хамтран Буянт гол дагуу завьт эргүүлийг ажиллуулж, амарч зугаалж байгаа иргэдэд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдийг голын ойр харгалзах хүнгүйгээр тоглуулахгүй байх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар 350 гаруй иргэнд яриа таниулга хийж, 3 төрлийн 1050 ширхэг санамж сэрэмжлүүлэг тараан өгч ажиллав.

Гол усны аюулаас урьдчилан сэргийлэх талаар сурвалжлага мэдээ 1, постер 1, сэрэмжлүүлэг 1, тарваган тахлаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг 1-ийг тус тус бэлтгэн байгууллагын цахим хуудас болон Ховд телевизээр дамжуулан иргэд олон нийтэд хүргэж мэдээллээ.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран хурдан морь унаач хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч уяач нарт хүүхдийг болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж, 4 төрлийн 400 ширхэг санамж, сэрэмжлүүлэг бэлтгэн хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга бүхий видео болон постерын хамт Цагдаагийн газрын цахим хуудаст байршуулан иргэд олон нийтэд сурталчилсан.

Баяр наадмыг гэмт хэрэг зөрчилгүй тэмдэглэн өнгөрүүлэх, болзошгүй осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх талаар орон нутгийн Ховд телевиз, байгууллагын цахим хуудсаар дамжуулан эрх бүхий албан тушаалтны яриаг хүргэсэн бөгөөд 5831 хүн хандалт хийсэн байна.

Орон нутгийн “Ховд”, “Олон ястны” телевиз, “Гэр бүлийн радио” 104, Тэмүүлэл fm 89.1-тэй хамтран байгууллагын үйл ажиллагаа болон улс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэвтрүүлэг 2, зочны буюу ярилцах цаг 1, мэдээ, шөнийн сурвалжлага 14-ийг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэж, “Khovd.mn”, “Монцамэ”, “Khovdnews.mn” сайтад 3 удаагийн ярилцлага, мэдээлэл нийтлүүлсэн.

Тайлант сард аймгийн хэмжээнд нийт 206 гомдол мэдээлэл хүлээн авсны 56 буюу 27,2 хувийг гэмт хэргийн шинжтэй, 150 буюу 72,8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлж байна. Бүртгэгдсэн 44 гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл: Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 12, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 3, хулгайлах гэмт хэрэг 7, залилах гэмт хэрэг 13, хүчиндэх 2, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харилцаанд орох 1, нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах 1, эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглах 1, хууль бусаар мод бэлтгэх 2, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн аюулгүй байдлын журам зөрчих 2 тус тус зөрчил бүртгэгдсэн.

Хүлээн авсан гомдол мэдээллийг төрлөөр нь авч үзвэл: Бусдын биед халдах 6, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 22, залилах 8, зам тээврийн осол 11, ЗХАБЖЗ 4, мал хулгайлах 2, хулгайлах 9, хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 18, хууль сахиулагчийг эсэргүүцэх 7, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 1, худалдаа үйлчилгээний журам зөрчсөн 1, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 4, хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг 4, цахим-доромжлох, гүтгэх 1, хууль бусаар мод бэлтгэх 3, танхайрах 1, бусад 104 гомдол мэдээлэл тус тус хүлээн авч, дээрх хугацаанд зөрчил гаргасан 98 хүнийг эрүүлжүүлж, зөрчил гаргасан 208 хүнийг 39.475.00 төгрөгөөр торгож, хурд хэтрүүлсэн болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 58 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 56 хүнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчилж шийдвэрлэлээ.

Улсын бүртгэлийн хэлтэс: Тус хэлтэс нь тайлант сард нийт 2287 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас Иргэний бүртгэлийн чиглэлээр 1724, үүнээс аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд 449, шилжиж ирсэн иргэд 65, аймаг доторх 192, сумаас суманд 72, багаас багт шилжсэн 120 байна.

Гадаад паспортыг 42 иргэнд олгож, 164 иргэнд шинээр иргэний үнэмлэх олгож, 176 иргэний үнэмлэхийг сунгалт хийж, 115 иргэнд дахин үнэмлэх олгов.

Иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлээр нийт 294 иргэнд үйлчилгээ үзүүлснээс үүнээс төрөлт 191, үрчлэлт 3, овог, эцгийн нэр, нэр өөрчлөлтийн бүртгэл 7, эцэг тогтоолт 4, гэрлэлт 24, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 2, нас барсны бүртгэл 32, 31 иргэнд нөхөн бүртгэл хийлээ.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 470, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 86 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажиллав. Иргэдээс нийт 7 өргөдөл, санал хүсэлт ирснээс хуулийн хугацаанд 5 шийдвэрлэж, 2 өргөдлийн хугацаа болоогүй шийдвэрлэлтийн шатандаа байна.

Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсролын чиглэлээр: Элсэлтийн ерөнхий шалгалтыг БСШУС-ын сайдын тушаал, Боловсролын үнэлгээний төв, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймгийн Онцгой комиссын зөвлөмж, чиглэлийн дагуу 2020 оны 07 сарын 02-05-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Шалгалтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг 2020 оны 06 сарын 20-ны өдрөөс эхлэн шалгалтын байранд ажиллах хүний нөөцийг бүрдүүлж холбогдох дүрэм, журмыг танилцуулж ажилласан.

Элсэлтийн ерөнхий шалгалтын төвөөр Жаргалант сумын 2 дугаар сургууль шалгалтын үндсэн төв, 2 дугаар төвөөр лаборатори нэгдүгээр сургуулийг сонгож ариутгал халдваргүйтгэлийг мэргэжлийн байгууллагуудаар хийлгүүлж, анги танхим ширээ сандал, орчин нөхцлийг боловсролын үнэлгээний төвөөс ирүүлсэн зааврын дагуу нэг ангид суух сурагчдын тоог 12 байхаар тооцон хүүхэд хоорондын зай 1.5-2м байхаар байрлуулан нэг ширээнд нэг сурагч суухаар суудал засаж бэлтгэн дугаарлаж бэлэн болгож, 32 зохион байгуулагч, 2 эмч, 12 үйлчлэгч, 48 хянагч багшид шалгалтын явцад баримтлах дүрэм журам, үүрэг харицлагын талаар тодорхой үүрэг чиглэл өгч ажиллав. Шалгалтын төвд нийтдээ 47 анги танхимыг дугаарлаж, ширээ сандлын хүрэлцээтэй байдлыг хангаж, 4 тусгай өрөөг бэлдэж, 16 ангийг камержуулж, давхар бүрд мөн сургуулийн гадна орчинд сурагчдын бөөгнөрөл үүсгэхгүй байх нөхцлийг бүрдүүлэн нэвтрэх хэсэг 3-ыг шалгалтын төв бүрд бэлтгэлээ.

Ховд аймагт шалгалт өгөхөөр бүртгүүлсэн 917, бусад газраас аймагт шалгалт өгөхөөр хүсэлт гаргаж шалгалт өгөх байршлаа өөрчилсөн 3 шалгуулагч нийт 920 шалуулагч 2413 шалгалт өгөхөөр бүртгүүлснээс дараах ирцтэйгээр шалгалтад хамрагдлаа:

Д/д	Хичээлийн нэр	Ирвэл зохих	Ирсэн		Ирээгүй	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Монгол улсын түүх	13	10	77	3	23
2	Англи хэл	332	311	93.6	21	6.3
3	Хими	201	184	91.5	17	9.2
4	Нийгмийн тухай мэдлэг	551	515	93.5	36	6.5
5	Газар зүй	16	14	87.5	2	12.5
6	Биологи	208	196	94.2	12	5.7
7	Математик	553	517	93.5	36	6.5
8	Физик	231	212	91.8	19	8.2

9	Орос хэл	18	13	72.2	5	27.7
10	Монгол хэл	290	262	90.3	28	9.6
Нийт		2413	2234	92.6	179	7.4

Боловсролын үнэлгээний төвөөс шалгалтын сэдэв аймгийн тагнуулын газраар дамжин ирсэн.

Шалгалтын сэдэв 1 дүгээр сургуульд 2-/02/-02-1, 2-/03-04-05/-03-2, 2-/06-07/-04-3, 2-/08-10/-05-4 дугаартай 4 хайрцаг, 2 дугаар сургуульд 2-/01-02/-02-1, 2-/03-04-05/-03-2, 2-/06-07/-04-3, 2-/08-09-10/-05-4 дугаартай 4 хайрцаг, гэрээний хуудас 2 хайрцаг нийт 10 хайрцаг битүүмжлэгдсэн материалыг тагнуулын газарт битүүмжлэн лацдаж шалгалтын хуваарьт өдрүүдэд шалгалт зохион байгуулах баг, мэргэжлийн хяналт, тагнуул, цагдаа, шалгуулагчдын хяналтан дор задалж, Боловсролын үнэлгээний төвийн 5 хүний баг бүрэлдэхүүнтэй хамтран зохион байгууллаа.

Аймгийн онцгой комиссын хурлаар аймгийн Жаргалант, Цэцэг суманд тарваган тахал өвчин гарсантай холбоотойгоор Аймгийн Засаг даргын 2020 оны 06 сарын 29-ны өдрийн А/340 дугаар захирамжаар Жаргалант сум, Цэцэг сумдын орох, гарах нийтийн тээвэр болон хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг 2020 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 22:00 цагаас эхлэн хязгаарласантай холбогдуулан аймгийн Боловсрол соёл урлагийн газрын даргын мэдээллийг хэлэлцээд дараах байдлаар шийдвэрлэсэн. Үүнд:

1. 2020 оны элсэлтийн ерөнхий шалгалтанд нийт 917 хүүхэд хамрагдана. Үүнээс хөдөө сумдын 380 хүүхэд байгаагаас 6 сарын 30-ны байдлаар 202 хүүхэд буюу 53 хувь нь аймгийн төвд ирчихсэн, 179 хүүхэд маргааш буюу 7 сарын 1-нд ирэхээр болсон байгаа.

2. Аймгийн Онцгой комиссын 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолоор МУ-ын хэмжээнд Элсэлтийн ерөнхий шалгалт 2020 оны 07 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд зохион байгуулахтай холбогдуулан хөдөөгийн 16 сумаас шалгалтанд орох хүүхдүүдийг багш, эцэг эхчүүдийн хараа хяналтан дор зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэлтэйгээр хяналтын постуудаар Жаргалант сумын нутаг дэвсгэрт нэвтрүүлэхийг үүрэг болгосон.

3. Хөл хориог хязгаарласан Цэцэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 27 сурагч элсэлтийн ерөнхий шалгалтанд хамрагдлаа. Эдгээр хүүхдүүдэд КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг мөрдүүлж ажилласан. Шалгалтын хугацаанд халуурсан болон ямар нэгэн өвчний шинж тэмдэг илэрсэн хүүхэд байхгүй байлаа.

Элсэлтийн ерөнхий шалгалтанд давхардсан тоогоор нийт 2413 шалгуулагч шалгуулахаар бүртгүүлснээс 2234 буюу 92,6% нь шалгагдаж, 179 шалгуулагч шалгалтанд ороогүй, шалгалт зохион байгуулах үед коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам, зөвлөмжийг мөрдөж ажиллалаа.

Эрүүл мэндийн чиглэлээр: Цэцэг суманд Тарваган тахлын сэжигтэй 2 тохиолдол илэрсэнтэй холбогдуулан салбар хоорондын мэдээлэл солилцох, шуурхай

арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих зорилгоор “Хариуцлагатай жижүүр томилон ажиллуулах тухай” Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны А/50 дугаар тушаалын дагуу 24 цагийн хариуцлагатай жижүүр томилон ажиллуулж, холбогдох мэдээллийг шуурхай авч аймгийн Онцгой комисст тухай бүр мэдээлж ажиллав.

Ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, учирч болох гамшгийн аюулын бэлэн байдлыг хангах зэрэг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр Khovdtimes, khovdnews.mn, newkhovd.mn сайтууд болон Ховд, Олон ястаны телевизүүдтэй гэрээлэн иргэд, олон нийтэд цахимаар мэдээлэл сургалт сурталчилгаа болон цаг үеийн мэдээллийг хүргэж, Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж гурван төрөл байршуулснаар 359 хүн, урин дулааны улирал, амралт аялалын цагаар эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдлээс сэргийлцгээе сэдвийн хүрээнд гурван төрлийн зөвлөмж байршуулснаар 945 хүн, ахуйн газны эрсдэлтэй холбоотой хоёр төрлийн зөвлөмжийг 831 хүн, үер усны аюул, ослоос сэргийлэх зургаан төрлийн зөвлөмжийг 1026 хүн үзэж танилцсан байна.

ДЭМБ-ын санхүүжилтээр ЭМЯ-аас зохион байгуулж буй “Коронавируст халдвар (COVID -19)-ын халдварын сэргийлэлт, хяналт, эмнэл зүйн менежмент” сэдэвт сургалтанд 100 эмч эмнэлгийн мэргэжилтнүүд, сургагч багш бэлтгэх сургалтанд 20 алба хаагч хамрагдаж бэлтгэгдлээ.

Ажлын байрны дагалдах сургалтанд хамрагдах эмч, мэргэжилтнүүдийн суралгааг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авахад 7 сумын эрүүл мэндийн төвөөс 12 чиглэлээр 25 эмч мэргэжилтэн, 2 өрхийн эрүүл мэндийн төвөөс 5 чиглэлээр 5 эмч мэргэжилтэн 5-14 хоногийн сургалтанд суралцахаар хүсэлтээ ирүүлсэн, байгааг хүлээн авч тус сургалтыг 11 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Халдварт өвчний тархвар зүй тандалт судалгааны хүрээнд халдварт өвчний тандалтын мэдээг хам шинжээр 7 хоног бүр авч, ХӨСҮТөвийн тандалтын албанд хүргүүлж байна. Тандалтын мэдээгээр тайлант сард цэврүүт халууралт тууралттай хам шинж 1, тарваган тахлын өвчлөл 2 нийт 3 өвчний тохиолдол мэдээлэгдсэн, Улаанбаатар хотод 21 хоногийн тусгаарлалтаас гарсан 8 хүнийг гэрийн ажиглалтанд хүлээн авч, иргэдийн мэдээллийг Халдварт өвчин судлалын үндэсний төвд тухай бүр хүргүүлж ажиллалаа.

ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанаас аймгийн хэмжээнд 23 анхан шатны нэгжүүдэд шаардлагатай 5 нэр төрлийн 19,053,150 төгрөгийн вакцин биобэлдмэл, дагалдах хэрэгслийг нэмэлтээр тооцоолон захиалж, хүлээн авч БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн захиалгын хуудсын дагуу хуваарилалт хийж, дархлаажуулалтын бэлдмэлийг зохих хэмд хадгалах, дархлаажуулалт хийх цэгүүдэд хүйтэн хэлхээний зарчмыг алдагдуулахгүйгээр хүргэхэд хяналт тавьж ажиллалаа.

Тарваган тахлын вакциныг Зооноз өвчин судлалын төв болон 14 сумын эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан Алтай суманд-1009х/т, Булгансуманд-500х/т, Буянт суманд-100х/т, Мөст суманд-594х/т, Мөнххайрхан суманд-500х/т, Үенч суманд-852х/т, Манхан суманд-484х/т, Дарви суманд-550х/т, Дуут суманд-200х/т, Чандмань суманд-

200х/т, Цэцэг суманд-800х/т, Эрдэнэбүрэн суманд-200х/т, Зэрэг суманд-200х/т, Ховд суманд-196х/т, ЗӨСТ-703х/т нийт 7088 хүн/тун вакцин хийж иргэдийг тарваган тахлын дархлаажуулалтанд хамрууллаа.

“Тэмбүүг устгая” үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс тэмбүүгийн эрт илрүүлэг, үзлэгийн 14 хоногийн мэдээг сард 2 удаа авч нэгтгэн аймгийн хэмжээнд нийт ХДХВ-ийн шинжилгээнд 15639, тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд 15641 хүн хамрагдсан. 6 сарын 16-наас 7 сарын 16-ний байдлаар ХДХВ-ийн шинжилгээнд нийт 2651, тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд 2794 хүн хамрагдаж 15 тэмбүүгийн халдвар шинээр оношлогдсон мэдээллийг ХӨСҮТ-ийн БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тандалт судалгааны албанд хүргүүлж ажиллав.

Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хэрэгжилтийн тоон тайланг харьяа эрүүл мэндийн байгууллагуудаас долоо хоног бүрийн 5 дахь өдөр авч нэгтгэн Эрүүл мэндийн яаманд хүргүүлж тайлант сард шинжилгээнд 516 хүн хамрагдаж, С вирусийн шинжилгээ эерэг гарсан 25, В вирусийн шинжилгээгээр эерэг гарсан 29 иргэнийг хяналтанд авч эмчилгээнд хамруулж байна.

Коронавируст халдвар (Covid-19)-ын сэргийлэлт, хяналт ба эмнэл зүйн менежмент, “Коронавируст халдварын үеийн хүүхдийн тусламж үйлчилгээ”, “Коронавируст халдварын үед эмнэлгийн мэргэжилтэн сэтгэлзүйгээ бэлтгэх, үйлчлүүлэгчид сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх нь” сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтанд Буянт, Мянгад сумдын эмч, эмнэлэгийн ажилчид нийт 36 хүн хамрагдлаа.

Сумын нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийн 3 дугаар улирлын ерөнхий гэрээний худалдан авалтаар авах 54 нэрийн эм, 5 нэрийн эмнэлгийн хэрэгслийн захиалгыг цахим дэлгүүр системээр дамжуулан захиалж, захиалгын дагуу 8 компаниас нийлүүлэгдэж буй 29 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг Эрүүл мэндийн газрын эмийн агуулахаар дамжуулан нийт 46,7 сая төгрөгийн ерөнхий гэрээний эм, хэрэгслийг нийлүүллээ.

2020 оны эхний 6 сарын байдлаар төрөлт 1128 мэдээлэгдсэн ба өмнөх оны мөн үеэс 35 төрөлтөөр, амьгүй төрөлт 7 мэдээлэгдсэн ба өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор, нас баралт 177 мэдээлэгдсэн ба өмнөх оны мөн үеэс 14 тохиолдлоор тус тус нэмэгдсэн, нялхсын эндэгдэл 18 мэдээлэгдсэн ба өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор, 0-5 насны хүүхдийн эндэгдэл 3 мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,5 дахь заалтын дагуу харьяа байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт 216504,7 мянган төгрөг, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтын дагуу 124019,6 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олголоо.

Тав: Сумдын мэдээлэл:

Мөнххайрхан сум: Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид Орон нутгийн сонгуулийн тойрог, мандатын тоо, төвийг тогтоох асуудлаар хуралдаж, тогтоол шийдвэрийг гаргаж, холбогдох газарт уламжлав.

Сумын төвийн Сэнхэрийн гол дагуух хог хаягдлыг сумын ЗДТГ-ын ажилтнуудын оролцоотой цэвэрлэж, аялагчид, амрагчдыг хог хаягдлаа ил задгай хаяхгүй байх, өөрийн аюулгүй байдлыг хангаж хоггүй цэвэрхэн аялах мэдээллийг цахим сайтад байршуулж, иргэдэд сурталчлав.

Манхан сумын малчид бэлчээрийн зөрчил гаргаж, Ендэрт чиглэлд зусаж байгаа мэдээллийг дагуу 2 удаа байгаль орчны хяналтын улсын байцаагч, хэсгийн мөрдөгч, багийн Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаж, мэдэгдэх хуудас өгч, гарсан шийдвэрийг танилцуулан, холбогдох арга хэмжээг авч ажиллав.

Бэлчээрийн хортон шавьж, царцаа устгалын ажлыг хийж, 2000 га-д хор цацаж устгах ажлыг “Мөнххайрхан царцаа хоршоо” гүйцэтгэж, хортон шавьж тархсан талбайн хэмжээ их, хуваарилагдсан хорны хэмжээ бага байгаа талаар холбогдох байгууллагад санал уламжлав.

Төрийн мэдээллийн хур системээс 10 иргэнд лавлагаа мэдээлэл өгч, ERP системд нутгийн захиргааны байгууллага, нэгж, албан хаагч, албан тушаалтны мэдээлэл орууллаа.

Сумын Эрүүл мэндийн төв Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 500 хүнд, тарваган тахлын голомтын бүс болох Борт багийн Бодонч, Баянсай чиглэл, төрийн албан хаагчдыг вакцинжуулалтад бүрэн хамруулсан.

Товлолын дагуу 42 хүүхдийг дархлаажуулж, бага насны хүүхдийн суурь өвчлөлөөс сэргийлэх зорилгоор зуны гэр сувилалыг 07 дугаар сарын 20-29-ны өдрүүдэд ажлуулж, 30 гаруй хүүхдийг уламжлалт аргаар эмчилгээнд хамруулаад байна.

Жаргалант сум: Сумын 14-35 насны залуучуудын мэдээллийн санд бүртгэлтэй түр оршин суугч иргэдийн судалгааг шинэчлэн гаргаж холбогдох байгууллагад хүргүүллээ. Багийн ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй, асаргаанд байдаг иргэдийн эмчилгээний зардал, рашаан сувилалд амарсан ахмадуудыг зардал, байнгын асаргаанд шинээр орж буй иргэн, жирэмсэн эх, цалинтай ээж хөтөлбөрт хамрагдах иргэдийн баримтыг бүрдүүлэн хүлээн авч аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт уламжлав.

Ковид -19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, байгалийн болзошгүй гамшиг болох үер ус, гал түймэр болон ахуйн ослоос урьдчилан сэргийлэх, осол гэмтэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай танилцуулга шторкыг цахим хуудсаар дамжуулан сумын 12 багийн иргэдэд мэдээлэл өглөө.

Аймагт тарваган тахлын сэжигтэй тохиолдол илэрч хэсэгчилсэн хөл хорио тогтоосонтой холбогдуулан айл өрх, аж ахуйн нэгжүүдэд тарваганы түүхий мах, эд эрхтэн хот суурин газарт оруулахгүй, эмчилгээний зорилгоор хэрэглэхгүй байх, тарвага болон мэрэгч амьтны бөөс, бүүрэгт хазуулахаас сэргийлэх, олноор үхсэн мэрэгч амьтад, тарвагатай таарвал гар хүрэлгүй мэргэжлийн байгууллагад яаралтай мэдэгдэх, тарвага агнахгүй байх, хэрэв тарваган тахлын эрсдэлд өртсөн, эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад яаралтай хандах

тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар боршур, зөвлөмжийг 400 гаруй иргэдэд хүргүүлж ажиллав.

Монгол улсын Засгийн газрын халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Тэмбүүг устгая” аянд сумын ОНХС-аас 1,5 сая төгрөгийн 746 ширхэг оношлуур тестийг Рашаант, Баатархайрхан, Бугат, Жаргалан, Буянт өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн. Сумын ОНХС-ийн 2.5 сая төгрөгийн санхүүжилтээр Жаргалант сумын 12 багийн суурь өвчлөлтэй болон уураг илчлэгийн дутагдалтай, цус багадалттай, хөгжлийн бэрхшээлтэй, амьжиргааны түвшин доогуур айл өрхийн 0-5 насны 250 гаруй хүүхдүүдийг зуны сувилал чийрэгжүүлэлтэнд хамруулж 250 гаруй хүүхдийг хамруулж эцэг эхчүүдэд хүүхдийн хооллолт, асаргаа сувилгаа, гэдэсний халдварт өвчин, осол гэмтлээс сэргийлэх талаар мэдээлэл өглөө.

Буянт голын зуслан дагуу эрүүл ахуйн шаардлага хангасан 11ш бие засах газрыг шаардлагатай цэгүүдэд нэмж байршуулав. Буянт голын сав дагуу дагаж мөрдөх шинэчилсэн журмын хэрэгжилтийг хүрээнд 3 ажлын хэсэг томилогдон зусланд түр буусан айл өрхүүдээс жилд нэг удаа хураамж авах, түүнийг зарцуулах, байгаль орчноо хайрлан хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж өгч, айл өрхүүдээс хураасан татварыг зуслангийн бүс нутагт бие засах газар, хогийн цэг байгуулах, хог хаягдлыг тухай бүрт нь ачиж зайлуулах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, иргэдэд нийгмийн болон хувийн хариуцлагыг ухамсарлуулах нөлөөллийн ажлуудыг хийхэд зарцуулсан, зуслангийн бүс нутагт байрлах 25 бие засах газар, 17 хогийн цэгт хлорын шохой, суперкилл бодисуудаар ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн тайланг хүргүүллээ.

Наадмын төв талбай, хурдан морины барианы газруудад хоол үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа 36 иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүнсний эрүүл ахуйг хангах болон “Ковид-19” халдварын үед үйл ажиллагаа явуулахдаа дагаж мөрдөх зөвлөмжийг тараан танилцуулж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу хяналт тавин зөвлөгөө өгч, жолооч нарт “Цэвэрхэн наадацгаая”, “Хандлагаа өөрчилъе” уриа бүхий 80 ширхэг машины наалтыг тарааж, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна, дотно болон морины барианд нийт 40 ширхэг хогийн сав, 6 ширхэг хогийн бункерыг байрлуулсан ба 2 өдрийн хугацаанд Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай гэрээ байгуулан зорилтод бүлгийн 16 иргэнийг авч цалинжуулан ажиллуулж баяр наадам үеэр болон дууссаны дараа морины бариа, цэнгэлдэх хүрээлэнгийн орчны хог хаягдлыг цэвэрлүүлж, хогийн цэгт буулгах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Буянт сум: сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант иргэдээс бичгээр 4 өргөдөл хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн, иргэний бүртгэл мэдээллийн үйлчилгээг нийт 181 иргэнд үзүүллээ.

Сумын Эрүүл мэндийн төв амбулатороор 121, урьдчилан сэргийлэх үзлэгээр 72, гэрийн идэвхитэй эргэлтээр 25 иргэн нийт 309 иргэнд үзлэг хийж, идэвхитэй хяналт 39 удаа хийлээ. Нийт 26 удаагийн дуудлагаар явж эмнэлгийн анхан шатны болон яаралтай тусламжийг цаг алдалгүй шуурхай хүргэж ажиллалаа.

Товлолын вакцинд 43 хүүхэд хамруулж, 0-3 сартай жирэмсэн 7 эхийг шинээр хяналтанд авч 24 өвчтөнд анхан шатны маягт хөтөлж, 36 нэр төрлийн 298,0 мянган төгрөгийн эм тариагаар үйлчиллээ.

Нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлтөнд хамрагдах хүсэлт ирүүлсэн иргэдийн баримтыг хүлээн авч, програмд оруулж байна. Ахмад настны нэг удаагын тэтгэмж тусламж болох шүд хийлгэсний үнийн хөнгөлөлтийг 7 иргэнд 700,0 төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хийлгэсэн шүдний үнэ 1 хүн 120,0 мянган төгрөг, УБ хот явж шинжилгээ хийлгэж эмчилгээнд хамрагдсан унааны нэг талын зардлын хөнгөлөлтийг 8 иргэнд 1252100 төгрөг олголоо. Хөдөлмөрийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийг нийтэд сурталчлан ажиллаж, хүнс тэжээл хөтөлбөрт 8 өрх хамрагдаж хүнсний дэмжлэг авч байгаа ба сардаа 552000 төгрөгийн санхүүжилт хийгдэж байна.

Сумын хэмжээнд тайлант сард 13 иргэнд холбогдох хуулийн дагуу хууль зүйн зөвлөгөө өгч, Хэсгийн төлөөлөгч, цагдаа нар хэв журам сахиулахаар шөнийн эргүүлд 20 удаа 120 цаг гарч, ахуйн дуудлагад 5 удаа, ахуйн шинжтэй 5 дуудлагын дагуу ажиллаж, эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаанд архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг хүнсний дэлгүүрүүдэд давхардсан тоогоор 15 удаа хяналт шалгалт хийж ажиллалаа.

Сумын Соёлын төвийн барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй, 8 дугаар сард ашиглалтад хүлээн авахаар төлөвлөн ажиллаж байна. Сумын Орон нутгийн хөрөнгөөр Хүүхдийн тоглоомын талбайг барих тендер шалгаруулалтыг олон нийтийн оролцоотой зохион байгуулж, Буянт сумын Оргил-Өндөр ХХК хийж гүйцэтгэхээр шалгарч барилгын ажлаа эхлүүлээд байна.

Дөргөн сум: Монгол улсын Тулгар төрийн 2229, Их Монгол улсын 814, Ардын хувьсгалын 99 жилийн ойн сумын баяр наадам 2020 оны 07 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Хурдан морины 6 насны 135 морь уралдаж, 38 унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, морины уралдааныг амжилттай зохион байгууллаа.

Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг нэвтрүүлж тайлант сард 11 байгууллагын 54 нэр төрлийн лавлагаа үйлчилгээгээр иргэдэд үйлчиллээ. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Нуурын хамгаалалт, Цаг уурын станцын хашаа, Соёлын төвийн тохижилтын ажлуудыг хүлээн авч хэвийн үйл ажиллагаа явуулж байна.

Аргалант багийн “Хөх эргийн аараг” хэмээх газар хууль бус алт олборлож байна гэсэн мэдээллийн дагуу 07 дугаар сарын 10-ны өдөр Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагч, сумын цагдаа нар хамтран хяналт шалгалт хийж, гар аргаар олборлолт хийж байсан иргэдийн багаж хэрэгслийг хураан авч, шийдвэрийн хуудас бичиж, торгуулийн арга хэмжээ авлаа.

Тайлант сард тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 289, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 27, тахир дутуугийн тэтгэвэр авагч 68 нийт 384 тэтгэвэр авагчдад 139368.1 мянган төгрөгийн тэтгэвэр олгож ажиллалаа. Сайн дурын

даатгалд нийт 244 даатгуулагчийн 15191.4 мянган төгрөг, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 12389.2 мянган төгрөгийн шимтгэлийн орлого тус тус төвлөрүүлж эрүүл мэндийн даатгалд 21 даатгуулагчийн 724.0 мянган төгрөгийн орлого орууллаа. Суманд бүртгэлтэй 75 аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудаас хагас жилийн буюу хоёрдугаар улирлын татвар, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь гаргуулан авч, цахим прагмомд шивж илгээсэн.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын “Эрсдлээс урьдчилан сэргийлэх тухай” 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 250 тоот зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, хүнсний 6 дэлгүүр, 3 хоолны газарт MNS 5021: 2007 стандартын дагуу хяналт шалгалт хийж, холбогдох заавар зөвлөмж өглөө.

Сумын Эрүүл мэндийн төв 23 удаагийн дуудлага хүлээн авч, 24 иргэнийг хэвтүүлэн эмчилж, амбулатороор 155 хүнд үзлэг хийж эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг шуурхай үзүүллээ. Эх хүүхдийн ноцтой хүндрэл гарахаас урьдчилан сэргийлж жирэмсэн эхийг хяналтанд авч тайлант сард БОЭТөвд 5 эхийг шилжүүлж, шинээр 4 эхийг хяналтанд авсан. Урьдчилан сэргийлэх шинжилгээ, оношлогоог тогтмол хийж, ДОХ тэмбүүгийн шинжилгээнд 92 хүн хамрагдсанаас 2 хүний хариу эерэг гарч эмчилгээнд хамруулж байна. Элэгний В,С вирусын шинжилгээнд 91, Сахарын шинжилгээнд 9, Хеликобактерийн шинжилгээнд 15 хүн тус тус хамрагдлаа.

Товлолын дархлаажуулалтанд 0-2 хүртэлх насны 45 хүүхэд, галзуугийн вакцин 4 хүүхдэд хийгдлээ. 6 сартайгаас 2 хүртэлх насны хүүхдүүдийг зуны чийрэгжүүлэх, сувилалд хамруулан биеийн дархлааг дэмжиж, ханиад томуу болон бусад өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 35 хүүхдийг 2 ээлжээр хамруулсан.

Коронавирус буюу ковид-19 халдварт өвчин, тарваган тахал, осол гэмтэл, үер усны аюул болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл зөвлөмжүүдийг сумын Эрүүл мэндийн төвийн цахим хуудсаар дамжуулан ард иргэдэд мэдээлж байна.